

“ЭЗЭН ЧИНГИС ХААНЫ БИЛИГ СУРГААЛ”-ЫН СУДЛАГДСАН БАЙДАЛ

С. Дашдэжид *

Монголчууд бид оюуны асар их өв соёлтой ард түмэн билээ. Үүнийг нотлох нэгэн дурсгал бол Их эзэн Чингис хааны билиг сургаал юм. Чингис хаан хөвгүүд, дүү нар, охид гүнж, шадар түшмэд нөхдөдөө айлдсан сургаалыг олон зууны туршид судар шастирт тэмдэглэгдэж, ардын аман билгээр уламжилж ард түмний оюун ухаанд шингэж ирсэн билээ.

“Чингис хааны билиг сургаал”-ыг тусгайлан тэмдэглэсэн ном судрыг “алтан ураг”-ийнхан ёс төртэйгээр нандигнан хадгалж, хүндэтгэлтэйгээр үе дамжин уншиж, амьдрал ахуйн явдал мөрдөө баримтлах гол чиг баримжаа болгодог байсан бололтой. “Юан улсын судар”-ын \1370\ 136 дугаар дэвтэрт “*Алтан авдарт хадгалж байсан Тайзу Богдын эрдэнэт сургаалыг гарган уншив. Түүний бие цогц сур гэрэлтэй, дуу аялгуу ялгам тод, харагсад олноор чих тавин, хичээнгүйлэн сонсохгүй байх нь үгүй*” [Намжил, 1990, 45] хэмээжээ.

Ийнхүү нандигнан хадгалж, эрхэмлэн дээдлэн, эрдэнэт сургаалыг нь бишрэн сонсож байсан “Билиг сургаал” болон түүний судалгаа өнөө ч үнэ цэнэтэй байсаар, судлан сурвалжилж, утга санааг нь ухаан ойлгож, дагаж мөрдсөөр байна.

Чингисийн билиг сургаалыг бичгээр уламжилж ирсэн төлөв байдлыг гаргасанг товчлон толилуулбал, Тусгайлан тэмдэглэж үлдээсэн эртний сурвалж бол “*Монголын нууц товчоо*”, Рашид-ад-Диний “*Судрын чуулган*”, Юан улсын судар, Лувсанданзаны “*Алтан товч*”, Рашпунцагийн “*Болор эрхи*”, Жамбын “*Асрагч нэртийн түүх*”, Дарма гүүшийн “*Алтан хүрдэн мянган хэгээст*”, “*Оюунтүлхүүр*” [Ш.Чоймаа], Галданы “*Эрдэнийн эрхи*”, Саган сэцэний “*Эрдэнийн товч*”, “*Хаадын үндсэн хураангуй алтан товч*”, “*Арван буянт номын цагаан түүх*”, “*Эртний хаадын үндсэн их шар тууж*”, “*Чингис хааны алтан товч нэртийн цэдиг*” зэрэг болно.

20 дугаар зууны эхэн үед хэдэнтээ эмхэтгэн хэвлүүлсэн байдал.

1. Профессор Ж.Цэвээн 1915 онд “*Суут богд Чингис хааны алтан сургаал оршив*” хэмээн хэвлүүлсэнг 1999 онд доктор Э.Пүрэвжав кирилл үсэгт буулган, тайлбар зүүлтийн хамт хэвлүүлсэн.
2. 1924 онд Судар бичгийн хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “*Чингис богдын дурсгалын түүвэр*” гэсэн товхимолыг 1926 онд Тэмгэт Бээжин хотод дахин

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Утга зохиолын тэнхим

хэвлэсэн. Үүнийг мөн доктор Э.Пүрэвжав 2000 онд кирилл үсэгт буулган, тайлбар зүүлтийн хамт хэвлүүлсэн.

3. 1925 онд Тэмгэт Бээжин хотод “*Чингис хааны цэдиг*” хэмээх ном хэвлүүлсэн. Тус номын сүүлийн 70 тал хуудас нь найман зүйлийн эхтэй, адил бус агуулгатай, билиг сургаалын зүйл бүхий тус тус зохиол юм. Үүнийг мөн доктор Э.Пүрэвжав 2012 онд кирилл үсэгт буулган, тайлбар зүүлтийн хамт хэвлүүлсэн.

4. Академич Ц.Дамдинсүрэн гуай 1959 онд “*Монголын уран зохиолын дээж бичиг оривой*” хэмээх дээж бичигдээ, Лувсанданзаны “Алтан товч”-оос зохистой хэсгийг ялган авч, “Чингисийн билиг” хэмээн гарчиглаж, тусгайлан оруулсан байдаг [Ш.Чоймаа, 2003, 118].

Академич Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын тойм”¹, номондоо “*Энэ билиг сургаал бол уран цэцэн үгээр хэлсэн товч шүлэг байна*” гээд агуулгын талаас нягталсан. Мөн өмнөх судлаачдын судалгааны тухай “*Попов эмхтгэн хэвлүүлсэн 1836 онд ба хожим 1915 онд Монголын нийслэл хүрээнд тусгай дэвтэр болж тугалган бараар хэвлэгджээ. Энэ зохиолоос хэдэн зүйл 1923 онд нийслэл Хүрээнд хэвлэгдсэн “Чингис богдын дурсгалын түүвэр” гэдэг зохиолд оржээ. Энэ сургаалын зарим хэсгийг Оросын эрдэмтэн П.М.Милиоранский 1920, В.Л.Котвич нар орос хэлэнд орчуулан хэвлэсэн ба сүүлийн үед В.Хайссиг түүхэн үндсийн талаар, И.Рахвильц 1982 зэрэг судлаачид судлан өгүүлэл бичсэн.*” хэмээн товч дурьджээ.

Сүүлийн жилүүдэд, “*Чингис хааны билиг сургаал*”-ын талаар судалгааны өгүүлэл, эмхтгэл, түүврүүд цөөнгүй хэвлэгдэн олны хүртээл болжээ. Энэхүү өгүүлэлд судалгааны ерөнхий тоймыг авч үзлээ.

Нэг. Судалгааны өгүүлэл

“Билиг сургаал” судлалаар хэд хэдэн жинтэй өгүүлэл бичигджээ. Энд профессор Ш.Чоймаа “*Их эзэн Чингис хааны билиг сургаалыг судлах асуудал*”², мөн “*Чингис хааны гүн ухаан шаашин соёлын бодлого*”³ Жамбал “*Лу.Алтан товч*” дахь билиг сургаалын тухай⁴, Д.Мишигдорж “*Их эзэн Чингисийн билиг сургаал дахь сурган хүмүүжүүлэх үзэл санаа*”, Э.Пүрэвжав “*Чингис хааны билиг сургаал*”, Г.Буянбат “*Чингис хааны билиг сургаалын учир*”⁵, В.Хайссиг, И.Рахвильц, Окада Хидэхиро нарыг өгүүллүүд байна.

Профессор Ш.Чоймаа “*Их эзэн Чингис хааны билиг сургаалыг судлах асуудал*” өгүүлэлдээ, билиг сургаалын бичгээр уламжилж ирсэн төлөв, эх сурвалж, цаашдын судалгаанд анхаарах зүйлийг дурьдаад, 1. “*Чингис хааны билиг сургаал*”-ын язгуур эх сурвалж нь монголын ард түмний олон үеийнхний оюун ухааны охь болсон ардын аман зохиол байсан. 2. “*Чингис хааны билиг сургаал*”-ын гол цөм, сүнс сүлдэр нь Их эзэн богдын унаган ухаан, төрөлхийн оюун байна. 3. Бусдаас сурч мэдэх, ялангуяа мэргэн эцэн хүний сургамж зөвлөмжийг тун эрхэмлэдэг байсан. Өөрөөр хэлбэл, эзэн Чингис

¹ Ц.Дамдинсүрэн “*Монголын уран зохиолын тойм*”¹, тэргүүн боть, Улаанбаатар, 1957

² Ш.Чоймаа “*Монгол судлалын өгүүлэлүүд*” Улаанбаатар, 2003

³ “*Үлэмж их Чингис хаан*” ОУЭШХ-ын эмхтгэл, Эрхэлсэн Ж.Болдбаатар, Улаанбаатар, 2002

⁴ Жамбал “*“Лу.Алтан товч” дахи билиг сургаалын тухай*”, ӨМБИС №3, Хөххот, 1968, 17 хуу

⁵ Г.Буянбат. “*Чингис хааны тухай судалсан өгүүллийн түүвэр*”, Хөххот, 2005, I дэвт. 69-75 хуу

хаан бээр дээд тэнгэрээс заяасан ухаан билгээ, дэлхийн мэргэдийн оюуны өв сангаар сэлбэн дэлгэрүүлэгч байжээ” хэмээн тэмдэглэсэн.

Доктор Э.Пүрэвжав: “Чингис хааны билиг сургаал” өгүүлэлдээ, “Чингис хааны алтан сургаал”, “Чингис богдын дурсгалын түүвэр”, “Чингис богдын зохиосон Алтан товч хэмээх шастир”, “Чингисийн хоёр эр загалын тууж”, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний цэцэлсэн шастир”, “Чингис хааны билиг”, “Чингис богдын зохиосон оюун түлхүүр” [1999-2005 онуудад жил дараалан хэвлүүлэн нийтлүүлсэн] тэргүүтэн түмэнд түгэн дэлгэрсэн долоон билиг сургаалын үзэл санаа, агуулгын талыг нягтлан үзээд, “Чингис хаантны агуу үйлсийг бүтээсэн хорвоод хосгүй гайхамигийг түүний билиг сургаал, айлдварын оюун дүгнэлт, үгийн урлал, ухааны чадамжаас нь эрэн сурвалжилбал зохино” хэмээн оновчтой дүгнэсэн байна.

Доктор Д.Мишигдорж “Их эзэн Чингисийн билэг сургаал дахь сурган хүмүүжүүлэх үзэл санаа” өгүүлэлдээ, “Эзэн богд Чингэс хааны билэг сургаалд төрөө дээдлэх, аав ээж, ахас ихсийг хүндлэх, өвгөд хөгшид, нялхсыг асрах, эе эвийг хичээх, эрдэм боловсролд хичээн суралцах, ажил хөдөлмөрт шамдах, сайныг дагаж, саарыг жигших, аливаа муу үйлдлээс ангид байх, хүн чанарыг эрхэмлэж, хэлсэн үгэндээ эзэн болох, бат журмыг сахих, сайн явдалд саруул ухаантай, эх орон ард түмэндээ халуун хайртай байх зэрэг хүний сайн сайхан чанарыг номлож сургасан нь сурган хүмүүжүүлэх чухал ач холбогдолтой юм. Чингэс хааны сургаал номлолыг маш нарийн судалж, сурталчлах нь өсвөр үеийг зөв боловсон хүмүүжүүлэхэд үнэлж баршгүй нөлөөтэй юм.” хэмээн агуулгын талаас нь нягталж сурган хүмүүжүүлэх үзэл санааг судалсан байна.

Хоёр. Судалгааны ном товхимол

Их эзэн Чингис хааны өв соёл, түүх, уламжлалыг олон талаас нь нягтлан судласан Ц.Дамдинсүрэн⁶, Э.Пүрэвжав⁷, Ш.Нацагдорж⁸, С.Цэрэнбалтав, Ц.Минжин⁹, Н.Нагаанбуу¹⁰, И.Бүрэн-Өлзий¹¹, И.Цоодол¹², Д.Дагдан¹³ мөн ОХУ-ын эрдэмтэн Б.Я.Владимирцов¹⁴, Өвөр Монголын профессор Сайшаал¹⁵, Х.Намжил¹⁶, Х.Буянбат¹⁷, Г.Мөнх¹⁸, Сарангоо¹⁹, Дэлгэрсан²⁰, Эрэнжен Хара-Даван²¹, П.Волфрум²² нарын эрдэмтэд судалгааны ном, товхимол гаргажээ.

⁶⁾ Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын тойм” I боть, Улаанбаатар 1957

“Монголын уран зохиолын дээж зуун билэг оривой”, Улаанбаатар, 1959

⁷⁾ Э.Пүрэвжав “Чингис хааны цадиг” Улаанбаатар, 2012

⁸⁾ Ш.Нацагдорж “Чингис хааны цадиг” Улаанбаатар, 1991

⁹⁾ С.Цэрэнбалтав, Ц.Минжин “Тэмүүжин-Чингис хааны билиг сургаал” Улаанбаатар, 2006

¹⁰⁾ Н.Нагаанбуу “Чингисийн зарлиг, гэрээслэл, билиг сургаал, ёс засаг”, Улаанбаатар,

¹¹⁾ И.Бүрэн-Өлзий. “Чингисийн билиг сургаалын гүн ухааны агуулга арга билгийн сэтгэлгээ”, Улаанбаатар, 1997, Магистрын зэрэг горилсон бүтээл

¹²⁾ И.Цоодол “Чингис хааны “Их засаг” хуулийн гол заалт, билиг сургаалууд” Улаанбаатар, 2000

¹³⁾ Д.Дагдан “Тэмүүжин-Чингис хааны бодгаль чанар” Улаанбаатар, 2004

¹⁴⁾ Б.Я.Владимирцов “Чингис хаан”, Улаанбаатар, 2001

¹⁵⁾ Сайшаал “Чингис хааны товчоон”, ӨМАХХ, Хөххот, 1987

¹⁶⁾ Х.Намжил “Чингис хааны засаг ба билиг”, Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо, Хөх хот, 1990

¹⁷⁾ Х.Буянбат “Монголын эртний билиг сургаал”

¹⁸⁾ Г.Мөнх “Монголын гүн ухааны түүхийн судлал”, Хөх хот, 1991

“Чингис хааны гүн ухааны үзэл санааны судлал” Ляонин, 1997

¹⁹⁾ Сарангоо “Монгол билиг сургаал”

С.Цэрэнбалтав, Ц.Минжин нар “Тэмүжин-Чингис хааны билиг сургаал” номондоо: Билиг сургаал, их засаг хуулийн уялдаа холбоо болон зааг ялгааг нарийн гаргаж, Өвөрмонголын эрдэмтэн Х.Мөнхийн Чингис хааны билиг сургаалыг “Хутуг билиг”, “Өв билиг”, “Өргөмөл билиг”, “Эш билиг” гэж дөрөв ангилсанг нэмэн дэлгэрүүлэн тайлбарлаж, мөн эх сурвалжуудаас билиг сургаалыг утга агуулгаар нь эзэн хаан ба төрийг засахуй, цэргийг засахуй, хууль цаазыг засахуй, эв эе, хэв журам бие сэтгэлийг засахуй, эр нөхрийг хүндлэн засахуй, аж ахуйг хөтлөхүй, эрдэмтэн мэргэд, шашиныг хүндлэхүй, архи дарсыг амсахуйн учир гэж найм ангилан, ажиглан, тайлбарласан байна.

Өвөрлөгч эрдэмтдээс Билиг сургаалыг хамгийн нухацтай судласан Х.Намжил “Чингис хааны засаг ба билиг” номондоо урьдах судлаачдын судалгааг нягтлан Билиг сургаал хийгээд их засгийн харилцаа холбоо, Билиг сургаалын буй болсон эх сурвалж, Билиг сургаалын уламжилж ирсэн эхүүдийн тухай, Билиг сургаалын агуулга ба үзэл санаа болон “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган”, “Лу.Алтан товч”, “Чингис хааны цадиг” болон бусад ном сурвалж дахи билиг сургаалыг түүвэрлэн, өөрийн нэмэлт тайлбар зүүлтийг хийсэн.

Ш.Нацагдорж “Чингис хааны цадиг” номондоо “Чингисийн хэлсэн билиг сургаал нь утга уянгын яруу чанартай гүн ухааны сэтгэлгээ бүхий байдгаараа онцлог юм. Чингис засаг хуулиар ард иргэдийг албадлагын хүчээр барьж байхыг бодсон бол бас ард түмнийг аргадан ятгах аргыг хэрэглэн баримтлан захирахыг хичээсэн байна. ...бодит амьдралаар тавигдсан асуудлыг өөрийн эрүүл саруул оюун ухааны үүднээс тайлбарлан өөрийн зориг самбаа идэвхитэй үйл ажиллагаагаар туурвидаг байсан гэж хэлэхэд болох юм” хэмээн дүгнэжээ.

Сайшаал “Чингис хааны товчоон” номондоо: “Чингисийн “билиг” эрдэмтэн мэргэд, жич ард иргэдийн уламжлалт зүйр сэцэн үгийг шингээн авч бүтсэн нь ч илэрхий юм. Ялангуяа баахан сүүлчийн үед тэмдэглэгдсэн нь бүр ч ийм шинжтэй билээ. Рашид-ад-Диний “Судрын чуулган”, Рашипунцагийн “Дай Юань улсын болор эрх” хэмээн бичигт нэлээд бүрэн системтэй тэмдэглэсэн байна. Энэ бол төрийг засах, ардыг гэгээрүүлэх ба монгол үндэстний боловсон дэвшилд дутааж болиггүй агуулга болно. “Билиг” буюу “сургаал” гэдэг нь хэрэг дээрээ өрлөг жанжин, сайд түшмэд олон зуун жил ард түмний дунд уламжлагдахдаа нэлээд баялагжин хөгжсөнийг эдгээр тэмдэглэлүүд харуулж байна. гэж дүгнэн бичсэн.

Доктор И.Бүрэн-Өлзий “Чингисийн билиг сургаалын гүн ухааны агуулга арга билгийн сэтгэлгээ” сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээлдээ, “Чингисийн билиг сургаал” нь бүхэлдээ эв нэгдлийн үзэл санааг голлон авч үзэж байгаагаараа онцлог юм. Арга билгийн сэтгэлгээний онцлог, мөн чанарыг танин мэдэж, түүнийг эзэмших, аливаа асуудалд хандахдаа нэгдлийн (шүтэн барилдахуйн) талыг гол болгон баримтлах явдал нь юмс үзэгдлийг танин мэдэх зөв сэтгэлгээний онол арга зүй болно хэмээн дүгнэж болох юм” гээд билиг сургаалын агуулгыг гүн ухааны түүхийн үүднээс тусгайлан судлаад, “Чингисийн билиг сургаалд аливаа хэрэг үйлсийн уг чанар, хувирал хөгжлийн жам ёсыг нээн илэрхийлсэн байдгаараа гүн ухаанлиг шинжийг агуулж байдаг бөгөөд

²⁰⁾ Дэлгэрсан “Чингисийн оюун гэрэл”, Хайлаар, 1993

²¹⁾ Эрэнжен Хара-Даван “Сод жанжин Чингис хаан, түүний үлдээсэн өв”, Улаанбаатар, 2003

²²⁾ П.Волфрум “Чингис хаан хийгээд түүний өв”, Улаанбаатар, 2007

энэ нь түүний үндсэн гол онцлог, гол мөн чанар хэмээн үзэж болно. Тиймээс “билиг сургаал”-ыг дорно дахины сэтгэлгээний өвөрмөц арга болсон “арга билгийн сэтгэлгээ”-ний үүднээс шинжлэн үзэж “монголын өвөрмөц онцлог бүхий гүн ухаан” гэсэн дүгнэлт хийсэн байна. Энэ нь Чингис хаан эртний дорно дахины гүн ухааны сургаал номлолыг сонсож, оюун ухаандаа шингээж алтан сургаалаа айлдаж байсны гэрч болой.

Гурав. Түүвэр, эмхтгэл

Эрдэм шинжилгээний судалгаа, ном товхимолоос гадна “Монголын нууц товчоо”, Лу “Алтан товч”, “Болор эрхи”, “Асрагч нэртийн түүх”, “Алтан хүрдэн мянган хэгээст”, “Оюунтүлхүүр”, “Эрдэнийн эрхи”, “Эрдэнийн товч” зэрэг түүхэн сурвалжаас түүвэрлэсэн Г.Аким²³, Ц.Нацагдорж²⁴, В.Нанзад²⁵, Ж.Ганболд²⁶, С.Ичинноров²⁷, Г.Алтан²⁸ нарын судлаачдын эмхтгэл, түүврүүд олноор гарсан байна.

Ц.Нацагдоржийн “Чингис хааны зарлигийн товчоон”, “Чингис хааны сургаалын товчоон” хэмээх хос бүтээл нь Чингис хааны билиг сургаалын эмхтгэлүүдээс хамгийн том, хамгийн олон билиг сургаалыг багтаасанаараа онцлог юм. “Чингис хааны зарлигийн товчоон”-нд Чингис хаан улс байгуулах, дэлхийг засан твшитгэхдээ тухайн зарлигийг хаана, хэзээ, юуны учир тийн айлдсан тухай түүхэн эшийг 203 зарлиг тус бүрийн эхэнд хураангуйлан үгүүлээд зарлигийн утга санааг айзам жигдрүүлэн наймаас арван зургаан мөрд багтаажээ. Түүнчлэн зарлиг тус бүрийн агуулгыг тодотгосон тайлбар дагалдуулсан. “Чингис хааны сургаалын товчоон”-нд Чингис хааны зарлигласан долоон зуу гаруй сургаалыг “Биеэ засах эрдэм”, “Гэрээ засах эрдэм”, “Төрөө засах эрдэм” хэмээн гурван бүлэг болгож, сургаал тус бүрийг зарлиг, сургаал, захиа, гэрээ, цээрийн аль альд багтан буйг ангилсан. Эртний хийгээд ховор хуучин үг хэллэгүүдийг тайлбарласан нь оновчтой, нилээн бүрэн гүйцэд байна.

Бусад судлаачдын хэвлүүлсэн эмхтгэл, түүврүүдийг ажиглахад тайлбар, зүүлт багатай, зөвхөн агуулгын талыг харгалзан түүвэрлэсэн, цөөн хуудас бүхий олон түмэнд ихэд дэлгэрсэн сургаалууд байна.

Ийнхүү “Чингис хааны билиг сургаал”-ын судалгааны ном бүтээлүүдийг багцлан дүгнэвэл,

Олонх судлаачид [Ш.Чоймаа, Э.Пүрэвжав, Х.Намжил, Г.Аким²⁹] “Чингис хааны билиг сургаал”-ын язгуур эх сурвалжийг дараахи байдлаар тайлбарлажээ.

1. Ард түмний оюун ухааны охь болсон ардын аман зохиол \зүйр цэцэн үг\
2. Эзэн богдын унаган ухаан, төрөлхийн оюун
3. Амьдралын туршлага, бусдаас сурч мэдэх, ялангуяа мэргэн сэцэн хүний сургамж зөвлөмжийг өөрийн оюун билгээр шүүн тунгааж сургаалаа айлдсан.

Мөн билиг сургаалыг [профессор Г.Мөнх]

²³⁾ Г.Аким “Чингисийн оюун билгийн соёрхол оршиг”, Улаанбаатар, 1999

²⁴⁾ Ц.Нацагдорж “Чингис хааны зарлигийн товчоон”, Улаанбаатар, 2006

Ц.Нацагдорж “Чингис хааны сургаалын товчоон” Улаанбаатар, 2006

²⁵⁾ В.Нанзад “Чингисийн сургаал гэрээслэл”, Улаанбаатар, 1991

²⁶⁾ Ж.Ганболд “Эзэн Чингисийн зэрлиг, гэрээс, билиг сургаалууд оршвой”, Улаанбаатар, 1992

²⁷⁾ С.Ичинноров “Богд Чингис хааны сургаалын түүвэр”, Улаанбаатар, 2004

²⁸⁾ Г.Алтан “Чингис хааны хэлсэн үг сургааль”, Дархан, 2010

²⁹⁾ Г.Аким “Хөрстөд ганц Чингис хаан буюу хөх монголчуудын өлзий учрал” Улаанбаатар, 2012

1. Хутаг билиг (хутагт төрсөн Богд эзэн гэж гарлыг тодочлон, Чингис хаан өөрийн биеэрээ шууд хэлсэн уг үг, уул санааг илтгэж байх сургаал)
 2. Өв билиг (Чингис хаан өөрөө айлдаагүй боловч бусдын хэлсэн сургаалыг таашаан өөрийн санааг илэрхийлсэн)
 3. Өргөмөл билиг (Чингис хаан хөвгүүд, дүү нар ба өрлөг сайдаа сурган үгүүлсэн буюу Чингис хааны ач гавъяаг магтаж өргөсөн зүйл буй түүний нэр төрийг ашиглан түүний гавъяа зүтгэлийг өргөн магтсан бусад хүний найруулан сургаал),
 4. Эш билиг (түүхэн материалд суурилж Чингис хааны үзэлт айлдварыг эшлэж орлон зохиосон)
- хэмээн ангилсан нь билиг сургаалыг уг сурвалж талаас нь судлахад дөхөмтэй хэрэг болжээ.

Сургаалын агуулга талаас нь,

Их хааны билиг сургаал нь утгын хувьд өргөн дэлгэр, уянгын хувьд яруу тансаг хэллэгтэй, онолын хувьд гүн ухааны оюунлаг сэтгэлгээтэй болохыг агуулгаас нь бүрэн мэдэж болно.

Биеэ тэжээх ухаан, гэрээ засах эрдэм, төрөө төвшитгөх засаглал [Боловсролын филисофи. 276] гэсэн ерөнхийгөөс төрийг засах, цэргийг засахуй, хууль цаазыг дээдлэхүй, эв эе, хэв журам бие сэтгэлийг засахуй, эр нөхрийг хүндлэн засахуй, аж ахуйг хөтлөхүй, эрдэмтэн мэргэд, шашныг хүндлэхүй, архи дарсыг амсахуйн учир [С.Цэрэнбалтав, Ц.Минжин] хэмээн төр ёс хууль цааз, бие хүмүүн болох, нийгэмдээ хэрхэн зөв төлөвших зэргийг сургамжилсан төдийгүй улам нарийсаж эцэг эхийн элбэрэл ачлалыг бишрэн хүндэтгэх, эрхэмлэн дээдлэх, ахас ихэсийг хүндэтгэн хамгаалах, үнэнчээр нөхөрлөх, хүнийг хайрлах, ухаалаг хандах, хүний үгийг сонсох, үнэнч шударга байх, нөхөртөө туслахыг эрхэмлэх, тусыг тусаар хариулах, эх нутгаа хайрлан хамгаалах, унаа малаа гамнах, анд нөхөр бололцох, хэлсэндээ эзэн байх, нэр төрөө эрхэмлэх, зорьсондоо хүрэх, хатуужил тэвчээртэй байх, нөхрөө хамгаалах, зарлигийг дагах, сайнаар үлгэрлэх, дэг журмыг сахих зэргээр хүмүүний алхам бүрийн үйлдийг сургасан сурган хүмүүжүүлэх, гүн ухааны цогц агуулгатай болохыг билиг сургаалаас бүрнээ мэдэрч болно.

Эцэст дүгнэн хэлэхэд,

Чингисийн билгийг уг сурвалж, агуулга, үзэл санааг судалсан судалгаа цөөнгүй байна харин ардын билигзүй, ардын аман зохиол, эртний дорно дахины бичгийн зохиолын уламжлал тархалттай холбон судалсан зүйл хараахан дутмаг байна, энэ талаар цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

НОМЗҮЙ

1. “Боловсролын филисофи”, боловсролын хүрээлэнгээс эрхлэсэн. Улаанбаатар 2012
2. Ц.Дамдинсүрэн, “Монгол уран зохиолын дээж зуун билэг оршвой”, Улаанбаатар, 1959.
3. Дэлгэрсан, “Чингисийн оюун гэрэл”, Хайлаар хот, 1993.

4. Ш.Нацагдорж, “Чингис хааны цэдиг”, Улаанбаатар, 1991.
5. Х.Намжил, “Чингис хааны засаг ба билиг”, Хайлаар, 1990
6. Сайшаал, “Чингис хааны товчоон”, Дэд дэвтэр, Хөх хот, 1987.
7. “Чингис хааны цэдиг”, Хөрвүүлж зүүлт тайлбарын хамт хэвлүүлсэн Э.Пүрэвжав, Улаанбаатар, 2012.
8. “Чингисийн оюун билгийн соёрхол оршвой”, Түүвэрлэн найруулсан Г.Аким, Улаанбаатар, 1999.
9. Ш.Чоймаа “Монгол судлалын өгүүлэлүүд” Улаанбаатар, 2003.

SUMMARY

In this article, author examines the scientific and research studies on “Chingis khaany bilig surgaal”. The scholars [Sh.Choimaa, E.Purevjav, Kh.Namjil, G.Akim] and source studies have have divided the work into the following:

1. Folklore - intellectual prowess and superiority of proverbs
2. Natural intelligence and wisdom of Ezen bogda
3. Life experience, learning from others and the wise men that use his mind to call upon past teachings.

Also professor G.Munkh has classified it:

1. Khutag bilig (his sayings and teachings)
2. Öv bilig (expressed his ideas enriching others teachings)
3. Örgömöl bilig (Chingis khan’s teaching and sayings to his sons, successors, generals and ministers; others’ sayings related to his success and deed)
4. Ish bilig (quotes on Chingis khan’s concepts based on historical source materials)

These classifications are helpful to do the further investigations.